

БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

“БАЯНХОНГОР АЙМГИЙН ОЙЖУУЛАЛТ-20” ХӨТӨЛБӨР

2000 ОН

БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

/3 дахь удаагийн сонгуулинн хуралдаан/  
2000 оны 12 сарын 15-ны өдөр Дугаар 2/6

Баянхонгор

Хөтөлбөр батлах тухай  
"Ойжуулалт-20" хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай аймгийн ИТХ-ын төлөөлөгч  
П.Зоригтбаатарын илтгэлийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ НЬ:

Дэлхийн цаг уур дулаарч, агаарын хуурайшилт, хөрсний цөлжилт эрчимтэй явагдаж байгаагаас манай аймгийн ойн сан 1993 онд 621.1 мянган га байсан бол 2000 онд 490.3 мянган га болж 130.8 мянган га-гаар хорогдож малын бэлчээр хомсдон, хүний амьдрах орчинд сөргөөр нөлөөлж байна.

Бэлчээр нутгийг цөлжилтөөс хамгаалах, түүний дотор төв, суурин газрыг хөрсний эвдрэл, агаарын бохирдлоос сэргийлэхэд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын тусламж дэмжлэгтэйгээр "Ойжуулалт-20" хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь чухал зорилт болж байна.

Ойн тухай хуулийн 23 дугаар зүйлийн нэг, гурав дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг. "Ойжуулалт-20" хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

Хоёр. "Ойжуулалт-20" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Гурав.Орчноо цэцэрлэгжүүлэх, хамгаалалт, арчилгааг технологийн дагуу хийх ажлыг хөрөнгийн эх үүсвэрийн хамт бүрэн шийдвэрлэж хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

Дөрөв. Айл өрх бүр мэргэжлийн байгууллагын туслалцаатайгаар хашаа, орон сууцныхаа орчинд мод, жимсний мод, зүлэг тарьж, ургуулах ажил зохион байгуулахыг төв суурин газрын оршин суугч, нийт иргэдэд уриалсугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Р. ЛХАГВАСҮРЭН

Д. БҮҮВЭЙ

## Баянхонгор аймгийн ОЙЖУУЛАЛТ-20 хөтөлбөр

**Өноогийн байдал:** Баянхонгор аймаг нь Сибирийн их тайгаас Төв Азийн говь цөлд шилжих хамгай, тал хээр, говийн 3 бүсэд орших 116 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай.

2000 оны 1 дүгээр сарын 5- ний байдлаар манай аймаг 20751 өрх, 90.0 мянган хүн ам, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд 20 сум, 99 баг, 1 тосгонтой, 2475.1 мянган толгой малтай байна.

Нутгийн хойд хэсэг нь Хангайн нурууны өмнө талын тэгш өндөрлөг болон ойт хээр, өмнөд хэсэг нь Алтайн цаад говийн цөлөрхөг бүсэд хамрагдана. Ихэнх нутаг нь далайн түвшнээс дээш 1000-1400 метр өргөгдсөн ба хамгийн нам дор цэг нь Эхийн гол (720 м), хамгийн өндөр цэг нь Их Богд уул (3957 м) юм.

Тус аймаг нь уур амьсгал, хөрсний олон бичил мужид хуваагддаг, нар, салхины эрчим хүчний нөөц сайтай, аймгийн нутгаар нь дэлхийн усан хагалбарын шугам дайрч өнгөрдөг, умардын хүйтэн чийглэг уур амьсгалаас өмнөдийн хэт хуурайд шилжих явцад үүссэн эрс тэс уур амьсгалтай зэргээрээ онцлог билээ. Агаарын температур нь хүйтний улиралд дунджаар -18 хэмээс -30 хэм хүртэл хүйтэн, дулааны улиралд +15 хэмээс +27 хэм хүртэл дулаан байдаг. Нутгийн хойд хэсгээрээ 12.6 мянган га шинэсэн, өмнөд хэсгээрээ 477.8 мянган га заган ойтой. 1993 онд Баянхонгор аймгийн ойн сан 621141га байсан бол 2000 онд 490380 га болж 132166 га-гаар хорогдсон байна. Үүний 94.8 хувийг заган ой эзэлж байна.

Сүүлийн жилүүдэд хүний буруу үйл ажиллагааны нөлөөгөөр тус аймгийн нутагт ургадаг зүйл ургамлаас сухай, хөх ногоон зээргэнэ, алтан гагнуур, үнэгэн сүүл, лидэр, алтайн сонгино гэх мэт 18 зүйл ургамал хөнөөгдөх, зайсангийн заг, улаан тулам, эмийн бамбай гэх мэт 32 зүйл ургамал ховордох, вансэмбэрүү, жигд гэх мэт 11 зүйл ургамал устаж болзошгүй аюул тулгараад байна.

Одоо Баянхонгор сумын хэмжээнд 14 уурын зуух ажиллаж байгаагийн зэрэгцээ өвлийн улиралд 4616 айл өрх энгийн галлагаат зуух ашиглан 57 мянган тн орчим нүүрс-шатааж байгаа нь мөн төдий хэмжээний хорт бодисоор агаарыг бохирдуулж байна гэсэн үг юм.

Байгаль экологийн тэнцвэр алдагдаж байгаатай уялдан тус аймагт тохиолдож байгаа ган, зудын давтагдал ихэсэж байна. Судалгаанаас үзэхэд тус аймагт 3 жил дараалан болдог зуд 6-12 жилд 1 удаа давтагддаг байна. Энэ давтагдал нь 1999-2001 онуудад тохиож байгаа бөгөөд 1999 онд гэхэд л нийт 6 сумыг хамарсан зуданд 135 мянган толгой мал хорогдсон байна.

Мөн үүнтэй уялдан хүн малын халдварт өвчний гаралт ч ихэсэх хандлагатай байгаа юм. Зөвхөн тарваган тахал өвчний тархалтыг сүүлийн 15 жилийн байдлаар авч үзэхэд 1985-1988 онуудад жил бүр 1 тохиолдол, 1990 онд 9 тохиолдол, 1998-2000 онуудад тус бүр 1 тохиолдол гарсан нь сүүлийн жилүүдэд уг өвчний гаралт дахин ихэсэж болзошгүй байдалд хүрч байгаагийн жишээ юм.

Мод, бут, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо тариалах ажлыг хүний тархинд итгэл үнэмшил болгож чадаагүй, байгаль орчныг хамгаалах сургалт, сурталчилгаа хангалтгүй, орчноо ногоон бүс болгон эрүүл мэнд, амьдарч буй нөхцлөө сайжруулах гэсэн идэвхтэй үйл ажиллагаа хэвшил болоогүйгээс өнөөгийн байдлаар хот суурин газрын нийт өрхийн дөнгөж 3.2 хувь буюу 230 орчим нь өрхийн тариалан эрхэлж цөөн тооны мод бут тариалж байна.

1989 онд 10989 га эргэлтийн талбайн 8393 га-д нь тариалалт хийж байсан бол 2000 онд тариалалтын талбай 167,3 га хүртэл буурч үндсэндээ 8 мянга гаруй га талбай атаршин ихэнх нь ургамлан нөмрөггүй, салхи, усны эвдрэл, элэгдэлд гүнзгий орсны дээр Түйн голын сав газарт 20 га, Хэрсэнгийн талд 8 га газрын

бургасан ой болон нийт 125,3 мянган га талбайн заган ойг дахин хэзээ ч сэргэшгүйгээр түлшинд ашиглан устгасан байна.

### **Хөтөлбөрийн үндэслэл**

1. Тус аймгийн байгаль цаг уурын нөхцөл, амьтны аймгийн бүтэц, тэдний тархалт, ургамлан нөмрөгийн био-экологийн суурь судалгаа, нөөц баялгийн үнэлгээ үндсэндээ хийгдээгүй, хүчтэй шороон шуурга, үер усны аюул, ган, зуд зэрэг байгалийн гамшгийн улмаас ургамлын зүйлийн бүрдэл өөрчлөгдөж ургамлан нөмрөгийн нөөц багасч, тархац дэлгэц нутаг нь хумигдаж байгаа.

2. Тус аймагт сүүлийн жилүүдэд техник технологийн шинэчлэл хийгдээгүй, ХАА үйлдвэрлэлийн технологийг зөв мөрдөхгүй байгаа зэргээс шалтгаалан экологийн тэнцвэрт харьцаа алдагдаж хөдөө аж ахуйн эдэлзлээр газрууд атаршин хөрсний элэгдэл эвдрэлийн хэмжээ ихэсэж байна. Үүний улмаас Баянхонгор аймгийн хангай, хээрийн ой мод, бургас шугуй, ургамал сүйтгэгдэж, бэлчээр талхлагдан, рашаан усны ундарга ширгэж, усны түвшин багассанаас гадна говь цөлийн нутгаар олон зүйл ургамал устах аюулд хүрч, элсний нүүдэл ихэсэж, цөлжих аюул нүүрлэх болсон.

3. Тус аймгийн нийт иргэдийн байгаль орчноо танин мэдэх, хайрлан хамгаалах зүй зохистой ашиглах мэдлэг, чадвар, дадлага дутагдалтай байгаагийн уршгаар агаар, хөрс усны бохирдол ихэсэж, хүн амын эрүүл мэндэд муугаар нөлөөлж, хүн амын дунд харшил, багтраа, хавдар, тарваган тахлын өвчлөл өсч байна.

4. Сүүлийн жилүүдэд БОЯ-аас ойжуулалтын ажилд зориулан хийгдэж байгаа санхүүжилт бүс нутагт нэгдсэн бодлого, хөтөлбөр, хяналт шалгалт байхгүйгээс үргүй зарцуулагдаж ойжуулах арга хэмжээнд дорипгой ахиц гарахгүй байгаа, ойгоос зөвшөөрөлгүйгээр их хэмжээний мод бэлтгэдэг зэрэг хүний буруу үйл ажиллагаанаас шууд шалтгаалж манай аймгийн ойн сангийн хэмжээ жил ирэх тутам буурч байна.

### **Хөтөлбөрийн онцлог давуу тал**

1. Баянхонгор аймгийн байгаль орчин экологийн хүчин зүйл, бохирдлын үнэлгээ ургамалжилтын тархац, нөөц, ховордол; ын талаарх шинжлэх ухааны тодорхой түвшний судалгаа, дүгнэлт гарсны үндсэы дээр зах зээлийн нөхцөлд энэ ажлыг зөв эрхлэн хөтлөх менежментийг сонгох нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэс болно.

2. Аймгийн нийт иргэдэд байгаль орчноо танин мэдэх, зүй зохистой ашиглах хайрлан хамгаалах, нөхөн сэргээх сэтгэл зүйн мэдлэг чадвар хандлага төлөвшүүлэх

3. Аймгийн нутаг дэвсгэрт цэцэрлэгжүүлэх, ойжуулах ажлыг мэргэжлийн нэгдсэн удирдлага, бодлого, арга зүй, хяналт, ур дүн, бүтэц үйл ажиллагааны цогц асуудалд зангидаж арга замыг сонгож тодорхойлсноороо онцлог давуу талтай болсон.

### **Ойжуулалт хөтөлбөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилго**

1. "Ойжуулалт" хөтөлбөрийн хүрээнд аймгийн нийт нутаг дэвсгэрийг хамарсан шинжлэх ухааны суурь судалгаа явуулсны үндсэн дээр цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, арга зүйг боловсруулна.

2. Мод бут сөөгийг тарьц суулгацаар тарьж ургуулах ажлыг аймгийн хөрс, цаг

уурын 3 бүсэд шинжлэх ухааны үндэслэлтэм, эрчимтэй явуулснаар элсний нүүлт, цөлжилтөөс хамгаалах, хөрс элэгдэл, эвдрэлд орох, бэлчээр доройтох явцыг зогсоох, гол горхи, рашаан, нууруудын ус ширгэх, агаарын болон усны бохирдлоос хамгаалах, хүн ам эрүүл, аюулгүй, таатай экологийн орчинд амьдрах ээрэг нөхцлүүдийг бүрдүүлнэ.

3. Мэдээлэл сургалт сурталчилгааны үйл ажиллагааг өсвөр үе, нийт иргэдэд байгаль орчин, ургамлын баялгийг танин мэдэх, зүй зохистой ашиглах, хайрлан хамгаалах, сэдэл тэмүүлэл, мэдлэг чадвар, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр зохион байгуулна.

### **Зорилтууд**

1. Мод, бут тариалах, хөрсний ургамлан бүрхэвчийн арвийг нэмэгдүүлэх, ногоон

байгууламжийн эзлэх хувийг нэмэгдүүлэх ажилд биолог-экологийн үндэслэл бүхий

орчин үеийн шинэлэг техник, технологийг нэвтрүүлсэн эргэлт гаргах

2. Ойжуулж зүлэгжүүлснээр ногоон ургамлын эзлэх хувийг эрүүл ахуйн зохистой

хэмжээнд хүргэн нэмэгдүүлж, хог хаягдал, олон салаа замыг цэгцлэх зэрэг ажлыг эмх

журамтай зохион байгуулснаар байгалийн элдэв бохирдол (ус, агаар, хөрсний)-ыг

багасгаж хүн амын экологийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг дээшлүүлэх

3. Мод, бут, жимс, жимсгэнэ үржүүлэх, төмс хүнсний ногоо тариалах, өргөнөөр

ашиглах, дахин боловсруулах явдлыг дэмжиж өргөжүүлснээр өрхийн орлогыг нэмэгдүүлж хойч үеийн эрх ашгийг дээдлэн, байгаль орчноо хайрлан хамгаалах уламжлалыг өвлүүлэн эзэмшүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулах

4. Мэргэжлийн хүмүүсийг мод үржүүлгийн ажил эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх

### **Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам**

1. Бодлого зохицуулалтын арга хэмжээг аймаг сумын засаг даргын тамгын газар хэрэгжүүлнэ.

2. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг ойжуулах хөтөлбөрийн зохицуулах зөвлөл .

3. Бэлтгэн нийлүүлэгч байгууллагад өгсөн захиалгыг үндэслэн тарьд суулгацыг ургах чадвартай болгон захиалагч байгууллагад худалдах зарчим дээр үндэслэнэ.

### Ойжуулах хөтөлбөрийн санхүүжилт

- Хөтөлбөрийн санхүүжилтийн механизм нь мод үржүүлэх, ой (заган болон навчит шилмүүст)-г сэргээх, ойжуулах, зүлэгжүүлэх хадлан бэлчээрийн талбайг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж буй иргэд аж ахуйн нэгжээс нийгмийн хэрэгцээ хангасан бүтээгдэхүүн худалдан авахад чиглэнэ.
- Ойжуулах, зүлэгжүүлэх ажлын нөхцөл бүрдүүлэх (үр суулгац, багаж материал, бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх) хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдийг ашиглах
- Ойжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд, улс аймгийн төсвөөс хувиарлах эх үүсвэр
- Төрийн болон хувийн змчийн байгууллагуудын өөрийн хөрөнгө
- Энэ чиглэлээр олдож болох гадаад орны зээл тусламжийн хөрөнгө
- Иргэдийн хөрөнгө

#### Гарч болзошгүй эрсдэл.

- Ган, зуд, түймэр, үер болон байгалийн гэнэтийн аюул осол.
- Төрийн бодлого өөрчлөгдөх
- Аймаг орон нутгийн удирдлага энэ асуудлыг анхаарлаасаа холдуулах.

#### Гарах үр дүн

1. Баянхонгор аймгийн цаг уур, ургамлын нөмрөгийн бүрдэл, хөрс, цөлжилт, байгалийн бохирдлын байдалд шинжлэх ухааны үндэслэлтэй хийсэн судалгааг үндэслэн дүгнэлт гаргаж байгаль орчныг хамгаалах иж бүрэн цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлнэ.


2. Байгаль орчноо танин мэдэх, хайрлан хамгаалах чиглэлийн сургалтын оновчтой агуулга, аргазүйг боловсруулан хэрэгжүүлснээр, хүүхэд багачууд, нийт ард иргэдийн байгаль орчноо танин мэдэх, хайрлан хамгаалах, нөхөн сэргээх сэдэл тэмүүлэл, мэдлэг чадвар, дадал, хандлагад чанарын дэвшил өөрчлөлт гарсан байна.


3. Хөтөлбөр хэрэгжсэнээр аймгийн ойн сангийн талбайн хэмжээ 1000 га-аар нэмэгдэж, тариалан эрхлэж буй өрхийн тоо 3500-д хүрч, төв суурин газарт 200 гаруй мянган мод, бут нэмэгдэж, хот суурингийн эдэлбэр газрын 10.6 хувийг ногоон төгөл, цэцэрлэгт байгууламж эзэлсэн байна. Дэлгэрэнгүйгээр 1-р хавсралтанд үзүүлэв.

#### Гүйцэтгэгч байгууллагууд

БОГХ-ны алба, ХААГ, Тохижилт үйлчилгээний газар, хэвлэл мэдээллийн алба, ʼургалт, боловсродын төв, МСҮТ, төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжүүд, айл өрх, иргэд.

#### Удирдлагын бүгэц





**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үүрэг, оролцоо:**

1. Мод үржүүлэх, суулгац, жимс, жимсгэний үрслэг бэлтгэх байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд газар олгох, эзэмшүүлэх асуудлыг шийдвэрлэх
2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд төр захиргаа, сургалт, судалгаа бизнесийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлэх .
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хэрэгжилтийн үйл ажиллагааны зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэх
4. Төвийн эрдэм шинжилгээний болон мэргэжлийн байгууллагуудыг хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцуулахад туслалцаа үзүүлэх
5. Ойжуулах, зүлэгжүүлэх арга хэмжээнд ард иргэдийг идэвхтэй татан оролцуулахад бүх талын үйл ажиллагаа явуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлүүдийг бүрдүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны төслүүдийг сонгон шалгаруулж санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх.
6. Ойжуулах, зүлэгжүүлэх, төрлийн ургамал тариалах онц сонирхолтой, идэвх зүтгэлтэй иргэдийн нөхөрлөл байгуулахад, тэдэнд санхүүгийн болон техникийн тусламж дэмжлэг үзүүлэх, урамшуулах, зээл олгох

**Сумдын ЗДТГгазар, багийн Засаг дарга нарын үүрэг, оролцоо.**

1. Өөрийн сум, багийн онцлогт тохируулан ойжуулах, зүлэгжүүлэх ажлын дэд хөтөлбөр боловсруулан, хийх ажлыг төлөвлөгөө, зураглалын үндсэн дээр жил бүрээр хэрэгжүүлэх
2. Өөрийн сум багийн нутаг дахь ногоон бүсийн хэмжээ байршлыг тогтоон байгалийн унаган бургас, харгана, дэрс заган ой, нуур цөөрөм, булаг шандны

орчныг тусгай хамгаалалтанд авч устаж үгүй болохоос сэргийлэх , хашилт хамгаалалт хийх, тодорхой хувь хүн, аж ахуйн нэгжид эзэмшүүлэх замаар нөхөн сэргээх, үржүүлэх арга хэмжээ авах

3. Энэхүү хөтөлбөрийн "Ногоон хувьсгал" хөтөлбөртэй уялдуулан иргэд, аж ахуйн нэгжид тариалан эрхлэх мод тарихад зориулан газар олгох

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн хэмжээнд шийдвэрлэх

5. Төв суурин газрынхаа хог хаягдлыг цэгцлэн ногоон орчинг хогоор бохирдуулахгүй байх нөхцлийг бүрдүүлэх.

### **Ойжуулах хөтөлбөрийн зохицуулах зөвлөлийн үүрэг, оролцоо.**

1. Ойжуулах хөтөлбөрийг аймаг, суманд хөгжүүлэх удирдах зөвлөлийн зохион байгуулж, сум, багийн дэд хөтөлбөр, гүйцэтгэх ажлын төлөвлөгөө зураглалыг хийхэд арга зүйн туслалцаа үзүүлж ажиллах

2. Хөтөлбөрт хамрагдаж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад олгох төсөв, төслийн болон зээлийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх

3. Айл өрх,аж ахуйн нэгжид ойжуулах ажил эрхлэх боломж, чиглэл зээл олгох нөхцөл байдлыг тодруулах судалгаа явуулж, зээл олгох авсан зээлийг зориулалтаар ашиглахад хөндлөнгийн хяналт тавих ,хугацаанд нь эргэн төлөгдөх оновчтой хувилбар сонгон хэрэгжүүлэх

4. Гүйцэтгэгч, хүлээн авч хэрэгжүүлэгч байгууллагын хоорондын гэрээ ажлын уялдааг сайжруулан үйл ажиллагаанд хяналт тавих

5. Газар тариалан эрхлэх, ойжуулах ажлын уулзалт зөвлөлгөөн, туршлага солилцох, үзүүлэх сургуулийг (ургацын баяр) зохион байгуулах

6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг жил бүр аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнаж байх.

### **Гүйцэтгэгч байгууллагуудын үүрэг, оролцоо**

1. Төмс, хүнсний ногоо, мод, жимс, жимсгэнэ үржүүлж тарйалах ажлын ач холбогдол арга ажиллагааны байнгын сургалт, сурталчилгааг явуулж аж ахуй эрхлэх арга барилыг иргэдэд эзэмшүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах

2. Ойжуулах хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэх ажлыг төсөл болгон боловсруулж хэрэгжүүлэх

3. Хөтөлбөр хэрэгжүүлэх эхний жилд гаднаас авах эх ургамлын сонголтыг өөрийн аймгийн хөрс цаг уурын нөхцөлд зөв тохируулан чанар сайтай ургамлыг сонгон авч тариалах цаашид үр үрслэг суулгацыг өөрийн аймагтаа үйлдвэрлэн зах зээлийн чанар сайтай үр суулгацаар хангах

4. Өрхийн аж ахуйн багаж хэрэгсэл үйлдвэрлэх, цас борооны усыг нөөцлөх энгийн аргуудыг сэдэн ашиглах, худаг, усалтын системүүдийг сэргээх, булаг шандыг тохижуулах зэргээр хөтөлбөр хэрэгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлүүдийг бие даан санаачлан зохион байгуулах

5. Ойжуулах ажлыг төмс хүнсний ногоо тариаллах тахиа, гахай үржүүлэх, ногоо дахин боловсруулах зэрэг чиглэлүүдийг хослуулан эрхлэж өргөжүүлэх

### **Төрийн болон төрийн бус бизнесийн байгууллагуудын оролцоо үүрэг**

1. Байгууллага аж ахуйн нэгж бүр ойжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөдөлгөөнд ажиллагсдаа идэвхтэй оролцуулан тэдний өрхийн тариалан эрхлэх мод, жимс жимсгэнэ тариалах ажилд бүх талын дэмжлэг үзүүлэх

2. Өөрийн эзэмшлийн болон ашиглаж байгаа газар болон түүний эргэн тойрон 50



метрийн дотогш газрын олон наст тариалан зүлэгжүүлэх, мод суулган цэцэрлэгжүүлэх ажлыг байгууллагын хөрөнгөөр заавал хийж хэвшил болгох

### Боловсон хүчний менежментийн асуудлыг шийдвэрлэх арга зам

1. Орон нутагт ажиллаж амьдарч байгаа дээд, дунд мэргэжлийн биологч, экологч, агрономч, ой судлаач нарыг өөрсдийнх нь сонирхолоор ойжуулах болон цэцэрлэгжүүлэх чиглэлээр давтан бэлтгэж мэргэшүүлэх,
2. Тус аймгийн МСУ Төвд ойжуулагч, цэцэрлэгжүүлэгч бэлтгэх ангийг нээж мэргэжилтэй ажилчин бэлтгэх,
3. Ургамал, ногоо тарих хүсэл сонирхол бүхий ард иргэдэд зориулж курс, дамжаа зохион байгуулах,
4. Байгаль судлалын чиглэлээр сонирхолтой сурагчдыг байгаль шинжлэлийн чиглэлийн их дээд сургуулиудад аймаг орон нутгийн захиалга, хөрөнгөөр тодорхой гэрээний дагуу сургах

1-рхавсралт

### Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, хүрэх түвшин

Үе шат	Хугацаа /оноор/	Хүрсэн байх түвшин (зорилт)
I үе	2000-2004	1. Жилд 25-30 мян.ш мөчрийн тайраадас бэлтгэх хүчин чадал бүхий 2 га эх ургамлын талбай байгуулна. 2. Жилд 245 мян.ш тарьц бэлтгэх хүчин чадал бүхий 8 га мод үржүүлгийн газар байгуулах 3.1000 өрхөд ойн зурвас бүхийтөмс хүнсний ногоо жимс жимсгэний эзэмшил газартай болгоно. 4. Төв суурин газруудад хамгаалалт бүхий 30 га талбайг цэцэрлэгжүүлнэ. 5. Ойн санг 70 га-аар нэмэгдүүлнэ
II үе	2005-2008	1.Ойжуулалт хийсний дүнд ойн санг 280 га-аар нэмэгдүүлнэ. 2.Аймгийн хэмжээнд 10 га талбайг суулгацаар цэцэрлэгжүүлнэ. 3.Сумын төвийн 1500 өрхийг хамгаалалтын зурвас бүхий тариалангийн эзэмшил газартай болгоно.
III үе	2009-2012	1. Ойжуулалт хийсний дүнд ойн санг 280 га-аар нэмэгдүүлнэ. 2.Сумын төвийн 2000 өрхийг хамгаалалтын зурвас бүхий тариалангийн эзэмшил газартай болгоно.
IV үе	2013-2016	1.Ойжуулалт хийсний дүнд ойн санг 280 га-аар нэмэгдүүлнэ. 2. Сумын төвийн 2500 өрхийг хамгаалалтын зурвас бүхий тариалангийн эзэмшил газартай болгоно.
V үе	2017-2020	1. 3500 өрхийг хамгаалалтын зурвас бүхий тариалангийн

		эзэмшил газартай болгоно. 2.Ойжуулалт хийсний дүнд ойн санг 280 га-аар нэмэгдүүлж, төв суурин газарт 30 га талбайд суулгац тарьж цэцэрлэгжүүлнэ.
--	--	---

2-р хавсралт

**Ойжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын урьдчилсан тооцоо**

Санхүүжилт хийгдэх үйл ажиллагааны чиглэл	Шаардагдах санхүүжилт /мян.төг/			Хийгдэх ажил
	1 жилд	Эхний үе шат	20 жилд	
Хөтөлбөрийн үйл ажиллагааны зардал	5500	22000	110000	Сургалт семинар зохион байгуулах
Айл өрх аж ахуйн нэгжид олгох жижиг зээл	5000	20000	100000	Өрхийн тариалан эрхэлж хот сууринг цэцэрлэгжүүлэхэд хувь нэмэр оруулсан иргэдийг шагнаж урамшуулах, эсвэл мод, суулгацаар зээл олгох
Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа, сургалт, зөвөлгөөн зохион байгуулах	6714	26856	134280	Сургалтын хөтөлбөр, цуврал ном, зөвлөмж, гарын авлага бэлтгэх
“Байгаль ээж” сонин бэлтгэх	1400	5600	28000	Иргэдэд байгаль орчноо хайрлах, хамгаалах, мод бут тарих зөвлөмжийг улирал бүр цувралаар гаргах
Оны шилдэг сум, баг, хамт олон, хувь хүнийг шалгаруулах	1535	6140	30700	Байгаль орчноо хамгаалах идэвхийг өрнүүлэхийн тулд эдийн засгийн хөшүүрэг хийх
Эх ургамлын талбай байгуулах, сайн чанарын эх ургамал сонгон худалдан авч тариалах	4500	4 удаа	18000	5 жил тутамд эх ургамлын плантаци бэлтгэж ургамлын удмыг сэргээх
Баянхонгор аймгийн ургамлын “Улаан ном” туурвих	620		620	Аймгийн нэн ховор ургамлын зүйлийг тодотгох, хамгаалах
Баянхонгор аймгийн ховор ховордсон ургамлын, ойн сан, цаг уур болон хөрсний хээрийн судалгаа	1800		1800	Бээлчээрийн даац, хөрсний үржил шим, ургамлын зүйлийн бүрдэл% ойн сан, уур амьсгалын явц зэргийг тодорхойлно.
Шинэ тоног төхөөрөмж багаж үйлдвэрлэх,	3000	20000	60000	Шаардагдах техник тоног төхөөрөмж

худалдан авахад				үйлдвэрлэх, худалдан авах
-----------------	--	--	--	---------------------------

-----oO-----

\_\_\_\_\_